

## Гарчиг

- |   |       |
|---|-------|
| 1. Мэтгэлцээн ба сэтгүүл зүйн хэм хэмжээ                                      | 01-04 |
| 2. Мэтгэлцээний товч түүх.<br>Украинд мэтгэлцээн хэрхэн зохион байгуулдаг вэ? | 04-06 |
| 3. Мэтгэлцээний загвар, зохиол  | 07-35 |

## 1. Мэтгэлцээн ба сэтгүүл зүйн хэм хэмжээ

Мэтгэлцээн бол дэлгэцийн урлаг. Мэтгэлцээн зохион байгуулахад дэлгэцэнд хэрхэн зөв зохистой, цэгцтэй ярих вэ, асуултаа хэрхэн зөв тавих вэ гэх мэт бэрхшээл тулгардаг. Мэтгэлцээнд нэр дэвшигчдийг хэрхэн урих, оролцож буй хүнээ эвгүй байдалд оруулахгүй байхыг яах вэ зэрэгт нарийвчлан суралцах хэрэгтэй.

Украинд бол мэтгэлцээн нь хөл бөмбөг зэрэг сонирхолтой нэвтрүүлгээс илүү олон үзэгчийг өөртөө татдаг.

### *Мэтгэлцээнд юу гол вэ?*

Эрх тэгш байх, ижил нөхцөл нөхцөл хамгаас гол юм. Яг л дуэль шиг. Үүгээрээ ч телевиз, радиогийн бусад нэвтрүүлгээс ялгаатай.

### *Мэтгэлцээнийг хэрхэн хөтлөх вэ?*

Их сайн зохион байгуулсан мэтгэлцээн нь хөтлөгчийн ур чадвар муугаас болж амжилтгүй болох тохиолдол бий. Гэхдээ мэтгэлцээнд хөтлөгчийн үүрэг, оролцоо бага байдаг.

Сургалт эхлэхийн өмнө бид зарим нэр томъёо ойлголтын талаар нэгдсэн ойлголттой болох нь чухал. Иймд сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээний тухай ярилцъя.

- Тэнцвэр- баланс (Сэтгүүлч бага оролцож, өөрийн байр суурийг гаргахгүй байхаас гадна олон үзэл бодол байх ёстой)
- Шуурхай байдал (Хуучин мэдээ байх ёсгүй. Урьдчилан бэлтгээгүй хүнийг нэвтрүүлэгт шууд оролцуулах нь түүнийг өөр өнцгөөс харах боломж олгодог. Урьдчилан бэлтгээгүй нөхцөл, орчинд өөрийгөө илэрхийлнэ гэдэг хэцүү. Тиймээс шуурхай байдал чухал. Шууд нэвтрүүлгийн үеэр хүн санамсаргүйгээр их чухал юм хэлж болно. Өмнө нь хэлнэ гэж бэлтгээгүй хрэнээ сандарч тэвдэхдээ үнэнээ хэлчихдэг. Улс

төрчид зовлонгүйгээр худлаа хэлдэг. Сайн сэтгүүлч хүнийг нээж чаддаг. Тэгж санамсаргүй байдлаар шинэ мэдээ үүсэхийг, тухайн мэдээллийг өгсөн хүнийг мэдээ бүтээгч буюу News maker гэнэ. Шууд нэвтрүүлгийн оролцогчид ихэнхдээ News maker болох боломжтой. Асуултаа бэлтгэсэн товч байх тусам олон нийт сайн хүлээж авдаг.)

▪ Тайлбар:

- Зарим оролцогч шударга байх нь мэргэжлийн сэтгүүл зүйн хэм хэмжээний нэг гэхэд багш тайлбар өгөв.
- Сэтгүүлчийн шударга, шударга бусыг шүүх нь хэцүү байдаг.
- Магадгүй шударга бус харагдахгүйн тулд сэтгүүлч аль болох бага ярих, товч байхыг эрхэмлэвэл хэрэгтэй. Учир нь сэтгүүлч их ярих тусам хэн нэгэнд шударга бус байгаа мэт сэтгэгдэл төрүүлнэ. Шударга бус санагдах үг хэн нэгэнд зайлшгүй байдаг.
  - Мэтгэлцээнд бэлтгэх явцад бүх зүйл маш тодорхой байх ёстой. Мэтгэлцээний загварыг оролцогчид мэдэж байх ёстой. Сэтгүүлч мэтгэлцээний үеэр үйл үгээр ярих тусам санаагаа зөв, товч илэрхийлдэг.)
- Баримтыг тайлбараас ялгах. Сэтгүүлч бид ямар нэг түүх ярьдаг. Тухайн асуудалд сэтгүүлч тайлбар хийгээд эхэлвэл шударга бус байдал бий болно. Жишээлбэл, миний гарт байгаа энэ ногоон үзгийг ногоон үзэг л гэж хэлэхээс би ногоон өнгөнд дуртай, ногоон бол сайхан өнгө гэх мэтчилэн өөрийнхөөрөө тайлбарлаад эхэлбэл шударга бус болно.
- Яг таг байх. (Тодорхой байх) Сэтгүүлч хүн өөрийн үзэл бодлыг илэрхийлж болохгүй.
- Эх сурвалж. Гурваас дээш эх сурвалжаар баталгаажуулах журам манайд үйлчилдэг. Украинд 2002 онд батлагдсан юм. Олон нийт сэтгүүлчдэд итгэх нь хамгийн чухал. Сэтгүүлч нэг удаа худлаа хэлж болно. Түүнийг

хэн ч анзаарахгүй байж болно. Хоёр дахиа худлаа ярихад эхнэр болон гэр бүлийнхнийх нь хэн нэгэн анзаарна. Харин гурав дахиа худлаа ярихад худалч болдог. Сэтгүүл зүй бол бидний тухай бусад хүмүүс юу гэж бодож байгаагаас хамаардаг бизнес. Тиймээс олон нийтийн итгэл дээр тогтдог.

## **2. Мэтгэлцээний товч түүх. Украинд мэтгэлцээн хэрхэн зохион байгуулдаг вэ?**

Телевизийн сэтгүүл зүй бол залуу. Улс төрийн анхны мэтгэлцээн 1960 онд болсон гэж түүхчид үздэг. Ж.Кеннеди Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихдээ энэхүү мэтгэлцээнд орсон нь ялалт авчирсан гэдэг. Ж.Кеннедид 1960 оноос өмнө сонгуульд оролцсон бол ялах боломж байгаагүй гэж судлаачид үздэг байна. Өөрөөр хэлбэл, Ж.Кеннеди залуухан, туршлагагүй, католик шашинтай байсан. Харин түүнтэй өрсөлдөгч Никсон туршлагатай, хижээл эр байлаа. Америкчуудын хувьд улс төрч нь католик шашинтай байхыг хүлээн зөвшөөрдөггүй байсан үс. Тиймээс Ж.Кеннеди 1960 оны сонгуульд телевизийн тусламж аваагүй бол ялах боломжгүй байсан гэж үздэг. Улс төрд телевиз ямар их ач холбогдолтойг олж харсанд түүний чадвар оршиж байсан. Ж. Кеннеди телевизийн мэтгэлцээнд Никсоныг дууджээ. Никсоны зөвлөхүүд оролцохгүй байхыг зөвлөсөн ч тэр оролцсон юм. Ж.Кеннеди залуухан, царайлаг, сайхан байсан бол Никсон царай муутай, өвдсөн, хорчгор, туранхай, уйтгартай хүн байжээ. Никсон телевизийн боломжийг олж хараагүйдээ алдсан гэдэг.

Телевизийн гол ид шид бүх зүйлийг томруулж, өсгөж, байгаагаас нь илүү харагдуулдагт оршдог. Үүнээс үүдээд Ж.Кеннедигийн ухаантай, гайхамшигтай гэх мэт давуу тал, Никсоны хамгийн муу, муухай чанар илүү тод харагдсан. Энэ бол дэлхийн мэтгэлцээний хамгийн анхны, хурц жишээний тоонд ордог.

1991 онд Украин тусгаар тогтносон. Яг тэр үед ямар нэгэн өөрийн хүч чадалгүй коммунист дарга нь ерөнхийлөгч болсон. 1993 онд хугацаанаас нь өмнө Ерөнхийлөгчийн сонгууль хийхээр болсон юм. Тэгэхэд царайлаг, ухаантай, эмэгтэйчүүдэд их таалагддаг гоё хүний эсрэг талд Украинаар муу

ярьдаг, үйлдвэрийн дарга, царай муутай хүн өрсөлдөж мэтгэлцээнд дуудсан. Нөгөө өрсөлдөгч түүнийг үл ойшоосон учраас дуудлагыг хүлээж авсан. Ерөнхийлөгч их гоё ярьсан. Харин үйлдвэрийн дарга “Хүмүүс ээ, би яагаад та нарын муу амьдарч байгааг мэднэ. Талхны буланг чинь олж өгье. Би үйлдвэр удирдаж байсан хүн. Улс удирдаж чадна” гэж хэлснээр амжилтанд хүрсэн.

2004 онд Украинд болсон мэтгэлцээнийг бүх Украин даяар хүн бүр санаж байгаа. Ерөнхийлөгчид хоёр хүн нэр дэвшсэн. Виктор Янукович, Виктор Ющенко нар. (Аг -ёүа гэгггёүа.) В.Янукович тухайн үед Ерөнхий сайд байсан. Тэрээр “Бид нар Оростой хамт байх хэрэгтэй. Европ хэрэггүй” гэсэн сонгуулийн уриатай байлаа. Харин Ющенко сөрөг хүчин байсан. Одоо Украины Ерөнхийлөгч.

Энэ бол түүхэн үйл ажиллагаа. Үүнээс өмнө Ющенког телевизээр харуулдаггүй байв. Тэр ганц сувгаар л гардаг байсан. Телевизээр өөрийнхөө үгийг хүргэх боломж байгаагүй. Яагаад энэ мэтгэлцээн Украины түүхийг өөрчилсөн бэ? Түүхэнд анх удаа сөрөг хүчний удирдагч үгээ хэлэх боломж олдсон юм.

Яагаад энэ мэтгэлцээнийг хийх боломжтой болсон бэ? Гэвэл хэд хэдэн шалтгаан байсан. Нэгдүгээрт, хүмүүс үүнийг үзэхийг их хүсч, үзэх сонирхолтой байгаа нь харагдсан. Одоо ч гэсэн Украины улс төрийн шууд шоу, ток шоуны рейтинг өндөр байдаг. Хоёрдугаарт, сонгуулийн мэтгэлцээн хуульчлагдсан. Хэвлэл мэдээллийн тухай хуулиар биш, сонгуулийн тухай хуулиар зохицуулдаг. Гуравдугаарт, Украины сэтгүүлчид үүнийг хийж чадах болтлоо мэргэжлийн хувьд өссөн байсан. Энэ мэтгэлцээнийг хийх гэж олон хүн хүчин зүтгэсэн. “Интерньюс” олон улсын байгууллага сонгуулийн хороотой нэг жил ажилласан. Ингээд сэтгүүлчид бид өөрсдөө Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр өрсөлдөгчдийн мэтгэлцээнийг хэрхэн зохион байгуулах тухай хуулийн зүйл заалтыг боловсруулж, шийдвэр гаргагчдыг зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүргэсэн.

Украины хууль өөрчлөгдөөгүй. Жилийн дараа энэ хуулиар Ерөнхийлөгчийн сонгууль явагдана. Манай сонгуулийн хуулиар мэтгэлцээн явуулах тухай нарийвчлан заасан байгаа. Оройн 7-10 цагийн хооронд явагдах

ёстой гэж заасан. Орост бол өглөө 6 цагт мэтгэлцээнийг цацсан. Украины энэ хуулийг хийсэн хүмүүс мэтгэлцээн нийгэмд ямар хэрэгтэй, ашигтай цагт хийх ёстой гэдгийг мэдэж байсан. Мэтгэлцээнд хоёр хүн л оролцоно гэж хуульчилсан. Түрүүчийн удаад Ерөнхийлөгчийн сонгуульд 24 нэр дэвшигч өрсөлдсөн. Хуулин дээр хоёр гээд бичээд өгсөн учраас өнөөдөр хоёр, маргааш хоёр, нөгөөдөр хоёр хүн өрсөлдөнө гэдгийг зааж өгч байгаа юм. Хэн хэнтэй оролцохыг сугалаагаар шоддог. Би энэ хүнтэй мэтгэлцэнэ, мэтгэлцэхгүй гэсэн зүйл срөөсөө байхгүй. Хуульд нэр дэвшигч биечлэн оролцоно гэж заасан. Мөн хугацааг 60 минут байна гэж зааж өгсөн. Мэтгэлцээнийг рекламаар таслахгүй гэдгийг мөн хуульчилж өгсөн. Украины хуульд нэг цагийн эфирийн 12 минутыг л рекламд зарцуулах ёстой байдаг. Гэхдээ рекламны хуулийг сонгуулийн хуулиар хориглодог. Тиймээс сонгуулийн хуулийн заалтыг баримталж, мэтгэлцээний явцад реклам цацдаггүй. Мэтгэлцээнийг зөвхөн улсын нэг телевизээр зохион байгуулна. Харин хувийн, арилжааны бусад телевиз үнэ төлбөргүй дамжуулж, нийгэд хүргэх эрх эдэлдэг. Мэтгэлцээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Та нарын хэсгээс нь үзсэн мэтгэлцээнийг улсын төв телевиз зохин байгуулж, телевизийн 8 суваг цацсан.

Манай улсад Парламентийн сонгуулийн үеэр мэтгэлцээ явуулахад хууль зөрчилтэй. Нэг хуульд сурталчилгааг төлбөртэй явуулна гэж заасан, гэтэл өөр нэг хуулинд үнэ төлбөргүй сурталчилна гэсэн байдаг. Үнэ төлбөрийг нарийвчлан заагаагүй. 2006 оны Парламентийн сонгуулиар телевизийн сувгуудын 50 хувь нь мэтгэлцээн сайн хийж, үлдсэн 50 хувь нь реклам маягаар муу хийсэн. Нэг удаа 100 мянган доллараар 40 минутын мэтгэлцээн хийнэ гэж зарлаад зохион байгуулсан. Гэхдээ мэтгэлцээний чанар мөнгөний хэмжээнд байгаа биш. Мөнгөний тоо хэд байх нь асуудал биш. Хууль муу учраас сонгуульд өрсөлдсөн 40 намаас хоёрт нь л төлбөртэй мэтгэлцээн хийх боломж олдсон. Энэ мэт чухал хуульд сэтгүүлч бид өөрсдөө оролцох зайлшгүй шаардлагатай.

Манай мэтгэлцээн Америкийн мэтгэлцээнээс их өөр. Тиймээс ч намайг урьсан байх. Украины яруу найрагч Тарас Шевченко “Боритесь - Поборете” гэж хэлсэн. Энэ нь “Тэмц, тэгвэл ялна” гэсэн үг юм.

### 3. Мэтгэлцээний загвар, шаардлага, зохиол

Мэтгэлцээний сонгодог загвар гэвэл хөтлөгч, оролцогч, зочдоос бүрдсэн, өрсөлдөгчдөд тэгш боломж олгоход оршдог. Тухайн телевиз сонгодог загварыг баяжуулах боловч мэтгэлцээд дор дурдсан үндсэн шаардлага тавигддаг. Үүнд:

- Хөтлөгчийн үүрэг, оролцоо бага байна
- Өрсөлдөгчдөд үзэл бодлоо илэрхийлэх тэгш боломж олгно
- Өрсөлдөгчдөд бие биедээ асуулт тавих боломж олгоно
- Өрсөлдөгчдөд нэг асуудлаар мэтгэлцэх боломж олгоно
- Өрсөлдөгчдөд асуултад хариулах, өөрийгөө илэрхийлэх адил тэнцүү цаг хуваарилна
- Хэн эхэлж хариулах, ярихыг шодно
- Мэтгэлцээнд зочдыг урьж, асуулт тавих боломж олгоно
- Сонгуулийн хуулинд зааж өгсөн
- Мэтгэлцээнийг рекламаар таслахгүй

Телевиз бол маш онцлогтой, олон нийтийн итгэл дээр тогтдог бизнес гэдгийг мартаж болохгүй.

Телевизийн аливаа нэвтрүүлэг нэг хүний толгой, гараар бүтдэггүй. Үүнд оператор, найруулагч, сэтгүүлч зэрэг хүн бүхний оролцоо хэрэгтэй. Тэгэхээр сайн төлөвлөгөө хэрэгтэй. Энэ төлөвлөгөөнөөс бүх хүний үйл ажиллагаа ойлгомжтой Төлөвлөгөөнд срөнхий оператор, найруулагчийн үйл ажиллагааг нэг бүрчлэн бичсэн байх ёстой. Хөтлөгч хаана, хэзээ гарч ирэх ёстойгоо мэдсэн байх ёстой. Энэ хөтөлбөр нь мөн зочдод нээлттэй байх ёстой. Зочид хэн хэний дараа ярих, хэн асуулт тавихыг мэдэж байх ёстой.

Мэтгэлцээн бол халз тулаан юм. Хамгийн гол нь оролцогчдын тэгш байдлыг маш сайн хангасан байх ёстой гэдгийг үргэлж санаж байх ёстой.

Мэтгэлцээний зохиол дараалал хэлбэрээр бичигдэнэ. Энэ нь оролцогчдыг тэгш байдалд байлгах нөхцөлийг бүрдүүлдэг. Ингээд та бүхэнд би

өөрийн бэлтгэдэг нэвтрүүлгийн дарааллыг үзүүлье. Би долоо хоног бүрийн пүрэв гараг бүрт энэ нэвтрүүлгийг эфирт гаргадаг.

д/д	Эхлэх цаг, минут	Камер хэн дээр байх	Агуулга	Үргэлжлэх хугацаа
1.	21.30	Шаченко	Танилцуулга	2 минут
2.	21.32	Хоёр хөтлөгч нэмэгдэж орно		

Эхний хүснэгтэд эхлэх цаг, мэтгэлцээний явцад хэзээ хаана заставка, , график гарах вэ гэх зэргийг үргэлжлүүлэн нэвтрүүлэг дуусах хүртэлх бүх цаг хугацааг нарийвчлан минут, секундээр бичнэ.

Яагаад би үүнийг үзүүлж байгаа вэ гэвэл энэ дарааллыг хуульд яаж тусгагдсаныг баримтаар харуулахыг зорьсон юм. Энэ мэтчилэн үргэлжлүүлэн бичихэд дараалал 20 хуудас болсон. Хуульд хэрхэн тусгасныг уншиж өгье.

Мэтгэлцээний үргэлжлэх хугацаа 60 минут. Мэтгэлцээн Украины Ерөнхийлөгчид нэг нэр дэвшигчийн үгээр эхэлж, нөгөө нэр дэвшигчийн үгээр дуусна. Хэн түрүүлж үг хэлэхийг сугалаагаар шийднэ. Жишээ нь, би эхэлж ярилаа гэхэд мэтгэлцээн миний өрсөлдөгчийн үгээр дуусгана. Мэтгэлцээний эхэнд ярих нэр дэвшигчийнүг хэлэх хугацаа 10 минутаас хэтрэхгүй, төгсгөлд үг хэлэх хүний хугацаа 5 минутаас ихгүй байна. Хоёр нэр дэвшигчийн хугацааг тэдний ар талд байгаа цагаар хянана. Эхний үг хэлсний дараагаар хоёр оролцогч бие биендээ ээлжлэн асуулт тавина. Эхний асуултыг үг хэлэхдээ хоёрт хэлсэн өрсөлдөгч тавина. Тиймээс хоёр дахь асуулт үг эхэлж хэлсэн хүнд ирнэ. Асуултын хугацаа нэг минутаас хэтрэхгүй, хариулт гурван минутаас хэтрэхгүй.

Асуулт хариултын минут уян хатан байж болно. 10 минут дотроо 8-9 минут байж болно. 60 минут учраас 2 минут эргээд олдож болно. Дутуу ярьсан минутаа нөхөж болдог. Мэтгэлцээн хэрхэн эхэлдгийг одоо үзэцгээс. (Бичлэг үзүүлэв.) Энэ бол студис бичсэн бичлэг. Студид хоёр нэр дэвшигчдийн хөгжөөн дэмжигчид байна. Цэнхэр ороолттой Януковичийн, улбар шар ороолттой Ющенкогийн хөгжөөн дэмжигчид. Мэтгэлцээн эхлэхэд өрсөлдөгчдийг студид оруулаагүй. Одоо дэмжигчид өрсөлдөгчдийг угтан авч байна. Дэлгэцэд



сэтгүүлч, оролцогчдын байрлалыг харуулж байна. Мэтгэлцээн эхэллээ. Дэлгэц дээр телевизийн хоёр сувгийн лого байгааг та бүхэн харж байна. Нэг нь үндэсний телевизийнх буюу ICTV нөгөө нь дамжуулж буй телевизийнх. Энэ загварыг бүгд ойлгосон байгаа.

Оросын Петух гэж ёгт үлгэр байдаг. Хөхөө, тахиа хоёр хоёр биснээ магтдаг. Та намайг магтаад би таныг магтаад бид хоёрт сайхан байна гэдэг шиг (инээв) Сэтгүүлчдийн тохуурхал үүгээр дуусахгүй шүү дээ. Бидний үзсэн мэтгэлцээн бол улсын чанартай, СЕХ хяналт тавьдаг, улсын төсвөөр хийгддэг. Сэтгүүлчид бид энэ хөтөлбөрийн сул талыг харж байна. Учир нь, улс ямар нэгэн юм заавал орхигдуулдаг төдийгүй ийм хэлбэрийн мэтгэлцээн залхуутай, сонирхолгүй болдог. Түүнчлэн ганцхан сувгаар дамжуулахад цөөхөн хүн үзэж магадгүй гэж айлж байсан.

Нэг удаа бид Интерньюсийн хүрээнд хамгийн том ажил гүйцэтгэсэн. Бид Украиндаа хамгийн том мэдээллийн арилжааны сувгийг татан оролцуулж мэтгэлцээн зохион байгуулахыг зорьсон. Интерньюс бол Украины мэдээллийн төв. Энэ байгууллага нь Украинд хамгийн анхны арилжааны сувгийг бий болгосон. Мөн 8000 сэтгүүлчийг сургасан байгууллага. Интерньюсийн хувьд ерөнхийлөгчийн мэтгэлцээн нь хамгийн үр дүнтэй, том төсөл гэж үздэг. Ингээд бид Америкт хийдэг шиг мэтгэлцээн хийхийг туршсан.

Америкийн мэтгэлцээний бичлэг үзүүлэв. 2000 оны Ерөнхийлөгчийн мэтгэлцээн нь улсых ч биш, аливаа нэг сувгийх ч биш. Мэтгэлцээнийг тусгай байгууллага бэлтгэдэг. Гадны ямар нэгэн нөлөө байхгүй, элдэв дарамт шахалт үзүүлж чадахааргүй тусгай байгууллага бэлтгэж явуулдаг. АНУ-д ийм байгууллага ганц биш хэд хэд байдаг. Мэтгэлцээн зохион байгуулах гэж байгаа газар нь маш том байх ёстой. Тиймээс ихэвчлэн спорт заал түрээсэлж, тусгай тайз засаж бэлтгэдэг. Яаж зохион байгуулсныг хар даа.

Техник тоног төхөөрөмж, найруулагч, оператор, сэтгүүлч гээд бүх хүнийг хөлсөлнө. Мэтгэлцээний үеэр зураг авч цацаж болно, гэхдээ бидэнд мөнгө төл гэдэг. Бүгд найрамдах намаас Жорж Буш, ардчилсан намаас Альберт Гор хоёр өрсөлдөж байв. Ерөнхий зарчмыг ойлгов уу? Үйл явц энэ загвараар явбал хэн ч энэ үйл ажиллагаанд нөлөөлж чадахгүй. Телевизийн бүх суваг мэтгэлцээнийг дамжуулан цацах эрхтэй учир надад таалагдаж байна,

таалагдахгүй байна гэсэн үг яриа гаргадаггүй. Эдгээр хүмүүс бол зохион байгуулж байгаа комиссын гишүүд. Энэ хүн оюутны холбооны ерөнхийлөгч. Танхимд ердийн үзэгчид, мөн тусгай зочид урд эгнээгээр суусан байна.

Мэтгэлцээний завсараар 2 минутын мэдээ орж байна. Мэтгэлцээн сонирхолтой үйл явдал учраас оюутнууд кафед хүртэл дүүрэн байна. Өрсөлдөгчид бие бие рүүгээ хааяа нэг харахаас бус үргэлж үзэгчид рүү хандаж байна. Мэтгэлцээний явцыг оюутнууд анхааралтай ажиглан шүүн хэлэлцэж байна. NBC суваг нэрд гарсан хүмүүсээс Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээний тухай ярилцлага авч, мэдээнд оруулж байна. Тусгайлан уригдсан зочид, шинжээчид мэтгэлцээнд асуулт тавих, тайлбар хийх эрхтэй оролцдог.

Украинд энэ загвараар мэтгэлцээн хийхийг эрмэлзэж, туршихад нийт зардал 250.000 доллар болсон.

Интерьюс нь мэргэжлийн, чадвартай, хараат бус байж чадах байгууллага юм. Бид мэтгэлцээнийг цацах талаар таван сувагтай тохиролцож чадсан байсан. Мэтгэлцээн явуулах, зохион байгуулах мөнгөө ч олсон. Олон газар тэр дундаа гадаадын донорууд, Украины сувгуудаас санхүүжилт авсан. Тиймээс энэ загвараар явуулахаар шийдсэн.

Украинд мэтгэлцээнд итгэх итгэл Америкаас бага. Тиймээс бид мэтгэлцээнд итгэх итгэл төрүүлэх зэрэг бүхий тусгай байгууллага байгуулахаар шийдсэн. Энэ нь Ажиглагчдын зөвлөл. 15 хүнтэй байх ёстой. Бүх Украин хүмүүсийн дунд нэр хүндтэй хүн байх ёстой. Ингээд хүүхдийн зохиолч, Спортын холбооны Ерөнхийлөгч, анхны Ерөнхийлөгч, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч гэх мэт нэр хүндтэй хүнээс Ажиглагчийн зөвлөл бүрдүүлж эхэлсэн. Тэдгээрт мөнгө төлөөд, харин тэд хөндлөнгийн хяналт буюу аудит хийхийг зөвшөөрсөн юм. Энэ зөвлөлийн хамгийн гол чухал хийх ажил нь нэр дэвшигчдийн тэгш байдлыг ажиглах ёстой. Энэ хүнд юу байна, тэр хүнд юу байна гэдгийг хянаж, мэтгэлцээн болох хугацааг нэг адил цагт зарласан эсэхэд хяналт тавих ёстой. Хамгийн гол нь эдгээр хүмүүс аудит хийхийг шууд зөвшөөрсөн юм. Мэтгэлцээний хамгийн гол чухал юм бол илүү хүнлэг, хүн рүү хандсан байх ёстой. Үүнийг тайлбарлая. Бидний боловсруулсан мэтгэлцээн гурван хэсгээс бүрдсэн.

Í ýää;äýýð õýñý нэр дэвшигчийг олон нийтэд танилцуулах. Үзэгчдэд танилцуулсан буюу тэдний тухай ярьсан. Эсвэл өөрсдийнх нь бэлтгэсэн роликийг цацсан. Үүнд ямар нэгэн хяналт, хязгаар тавиагүй. Тэд өөрсдийн дураар бэлтгэж ирсэн. Сурталчилгаа, сюжет байж болохоор байсан. Ямар нэгэн формат заагаагүй, зөвхөн хугацаагаар нь хэмжиж, доторх агуулгад нь оролцоогүй. Видео роликийн дараа өөрсдийн үгээр өөрийгөө танилцуулах байсан. Энэ хэсгийн төгсгөлд телестост ашиглах байсан. Өрсөлдөгчид зөвхөн студид суусан хүмүүсийн асуултанд хариулах биш, алслагдсан үзэгчдийг татан оролцуулах зорилгоор телестостийг бэлтгэсэн.

Õí\_äáóäääð\_õýñгийн хугацаа 60 минут. Улсын мэтгэлцээнд энэ хэсэгт хоёр өрсөлдөгч юуны ч тухай ярьж болдог бол бид энэ мэтгэлцээнээ өөр замаар хийсэн. “Нэр дэвшигчдээс жирийн хүмүүс юу хүсч байна вэ?” гэсэн тусгай судалгааг захиалгаар хийлгэсэн. Судалгааны үр дүнд хүмүүс маш энгийн зүйл хүсдэг нь илэрсэн. Ихэнх үзэгч улс төр сонирхдоггүй болох нь тодорхой харагдсан юм. Тэд юу сонирхдог вэ?

1. Нийгмийн хамгаалал
2. Тэтгэвэр
3. Ажил, ажлын байр
4. Эрүүл мэнд
5. Боловсрол

Эдгээр багц сэдвийн тухай сонсохыг энгийн үзэгч нэр дэвшигчээс хүсч байсан. Цуврал мэтгэлцээний хоёр дахь хэсэг бүрт эдгээр асуудлыг нэг нэгээр нь оруулахаар төлөвлөсөн байв. Улс төрчид жирийн иргэд юу хүсдэгийг мэднэ гэдэг худлаа, харин юу хүсдэг гэдгийг бид ингэж гаргаж өгсөн. Эдгээр нь улс төрчдийн хариулт өгөх хамгийн дургүй сэдэв. Нэр дэвшигчид 60 минутийн турш дээрх сэдвийн аль нэгээр ярих ёстой байсан. Бидний төлөвлөгөөгөөр тус мэтгэлцээн 90 минут яваад завсарлана. Энэ завсарлагаанаар бусад хэсэгтэй холбогдохоор төлөвлөсөн. Ингэхдээ олонд танил, нэр хүндтэй хүмүүсийг оролцуулахыг зорьсон.

Ἄοδαῖῖοῖῖῖῖῖ ὀύῖῖῖ мэтгэлцээнийг үзэж байгаа хүмүүсээс асуулт асуух хэсэг. Америкт хийдэг шиг микрофон барьж, гудамжинд гараад иргэдээр асуулт асуулгах уу? гэдгийг шийдэх хэрэгтэй болсон. Учир нь, энэ тохиолдолд бидний бэлтгэсэн загвар эвдэгдэх аюултай байв. Ер нь жирийн хүмүүс асуултаа оновчтой асууж чаддаггүй. Тиймээс бид хоёрдугаар хувилбарыг бодож олсон. Үзэгчдээс бичгээр авсан асуултаа компьютерт бичээд бүгдэд харагдахаар дэлгэцэнд байрлуулахаар шийдсэн. Нэр дэвшигчид дэлгэцэнд харагдах олон асуултаас хариулахаас сонгосон асуултынхаа тухай тайлбарлах байсан. Бидний төлөвлөгөөгөөр 90 минут буюу 1 цаг 30 минутийн нэвтрүүлэг байсан. Телемостийг нэг минут 30 секунд байхаар төлөвлөсөн.

Харамсалтай нь, нэр дэвшигч В.Янукович мэтгэлцээнд ирээгүй. Учир нь В.Янукович өөрийгөө бүрэн ялсан гэдэгт итгэлтэй байсан учраас ирээгүй. Манай мэтгэлцээн нь улсын мэтгэлцээний дараа болсон учраас тэрээр ийнхүү татгалзсан. Ерөнхийлөгчийн сонгуульд 24 нэр дэвшигч байснаас бид хамгийн гол хоёр нэр дэвшигчийг сонгож байсан.

Гэхдээ бид үүнийг бидний хамгийн амжилттай төсөл гэж одоо ч гэсэн нэрлэдэг. Үүнийг хийх гэж туршсанаараа бид Украины өнөөгийн сэтгүүл зүйг урагшлуулсан. Үүнээс өмнө Украины улс төрчид юу ч хэлэхгүйгээр мөнгө төлөөд хүссэнээ хийдэг байсан. Тиймээс нурсан боловч нураагүй төсөл гэж бид боддог.

Сурах явцыг хэзээ ч зогсоож болохгүй шүү дээ. Би зөвхөн багш биш, заах арга, аргачлалын комиссын гишүүн хүн. Хичээл заах арга аргачлал дээр байнга ажиллаж байдаг. Тиймээс би цаашид суралцах хэрэггүй гэж бодох боловч би бага дусал ч болсон мэдлэг олохыг зорьдог. Мэргэжил нэгт нөхдийнхөө бодол санааг мэдэхийн төлөө ажилладаг.

“Хайр татсан хүүхэд хоёр эхийн хөх хөхдөг” гэдэг шиг хөрөнгө мөнгө санхүүжилтийг олон газраас авч болно. Гадны санхүүжилтээр хийж байсан мэтгэлцээний жишээг бид өнөөдөр үзнэ. Нийгмийн байгууллага, олон улсын сангууд санхүүжилт өгдөг нь энгийн зөв үзэгдэл. Мэтгэлцээн хөлбөмбөг зэрэг энгийн нэвтрүүлэг хийхээс илүү зардал гардаг учраас мөнгө авах хэрэгтэй

Сэтгүүл зүйн стандартыг баримтлахгүйгээр мэтгэлцээн явуулах боломжгүй гэдгийг дахин давтан хэлье. Тэнцвэртэй байдалгүй бол мэтгэлцээн биш. Тиймээс тэнцвэрийг зөв хадгалах стандартыг дагах ёстой. Мөн өчигдрийн мэдээ гэж байдаггүй, шинэ мэдээ үүсч байгааг news maker гэх, шуурхай байдал, яг таг байх гэж бид зөвшилцсөн.

Монголд сэтгүүлчдийн болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эсрэг шүүхдэг жишээг би мэднэ. Украинд ч бий. Ямар ч хүн шүүхэд очоод телевизийн талаар гомдол гаргах эрхтэй. Украины хуулиар бол нэвтрүүлэг шууд явж байгаа тохиолдолд, мөн шууд мэтгэлцээн явж байхад тухайн зүйлийг ярьсан оролцогч хариуцлага хүлээнэ гэж заасан байдаг. Хамгийн гол нь юу чухал вэ гэвэл хоёр оролцогч, хоёр хүн шууд мэтгэлцээн, нэвтрүүлгийн үеэр бие бие муулж, гутаавал тухайн хүн хариуцлага хүлээхээс сэтгүүлч, редактор, хөтлөгч, тухайн суваг ямар ч хариуцлага хүлээхгүй гэж заасан. Тиймээс Украинд явагдаж байгаа улс төрийн мэтгэлцээн, нэвтрүүлэг, үзэгчдийн сонирхолыг татаж чаддаг. Нэг талаар шинэ мэдээ түгээгч болж байгаа нөгөө талаар сэтгүүлч үүнд ямар ч хариуцлага хүлээхгүй.

Дахин давтахад, хоёр оролцогч ижил тэнцүү боломж, хөнцөлөөр хангагдаагүй бол мэтгэлцээний үндсэн формат эвдэгдэнэ гэдгийг сайн санах хэрэгтэй. Практик дээр нэг нь хүчтэй гарч ирдэг. Эсвэл хоёулаа хүчгүй байдаг. Үүнд үнэнч шударга хандахаас гадна мэтгэлцээн бол телевизийн шоу гэдгийг ерөөсөө мартаж болохгүй. Ижил тэнцүү байна гэдэг үзэгчдийн сонирхлыг татна. Шоу учраас аль нь ялах бол гэж үзэгчид шимтгэн үзнэ. Үзэгчид шоу үзэх сонирхолтой. Тиймээс ялагч тодоохой байж болохгүй. Ижил түвшиний байна гэдгийг зөв ойлгох хэрэгтэй. Жишээ болгож үзүүлбэл Янукович, Ющенко хоёрын хувьд нэг нь тухайн үед Ерөнхий сайд байсан, нөгөө нь өмнө нь Ерөнхий сайд байсан. Сөрөг хүчний лидер гэдгээрээр танигдсан байсан. Нийт 24 нэр дэвшигч байхад хүмүүсийн сонирхол энэ хоёр хүн дээр татагдаж байсан. Америкийн ерөнхийлөгчийн сонгуульд бас л 20 гаран хүн нэр дэвшдэг ч ялах магадлал бүхий хоёр хүн дээр олны анхаарал тусдаг. Мэтгэлцээнд ижил тэгш чадамжтай хүн оролцох ёстой. Энэ бол шоу гэдгийг хэзээ ч мартаж болохгүй. Утсаар асуулт авах нь сайн хэрэг боловч телевиз гэж юу юм бэ? Үзэгчид


утасдаж байхад дэлгэц дээр юу үзүүлэх вэ? Энэ тухай дараалал дээр ч бичих ёстой.

*Vox-in-pops* хийж болно. Тэнцвэрт байдлыг хангасан 4-5 асуулт бэлтгээд гудамжинд гараад хүнээс урьдчилаад бэлтгэж болно. Ингэхдээ асуултын тэгш байдлыг анхаарах ёстой. Нэг оролцогчийн тухай асуухдаа “Тэр сайн хүн үү?”, нөгөө оролцогчийн тухай “Тэр хулгай хийсэн үү?” гэж асууж болохгүй. Асуултаар ч гэсэн тэгш байдлыг хадгалах хэрэгтэй. Телемост гэдэг дүрсээр илэрхийлэгддэг ойлголт. Асуулт асууж байгаа хүн нь дүрсээр өөрөө гарна. Үзэгчид мэдээллийнхээ 80 хувийг дүрсээс олж авдаг гэсэн судалгаа байдаг. Монголын нөхцөлд энэ их чухал гэж надад санагдаад байна.

Монголын телевизүүдийг харахад утсаар холбогдсон үзэгчид, хөтлөгч бие биеэ ойлголцдоггүй юм шиг анзаарагдсан. Мэтгэлцээний үеэр утсаар холбогдох нь сөрөг нөлөө үзүүлнэ. Шууд нэвтрүүлэгт утсаар асуулт авна гэхэд бидний найдаж байсан шиг сайн хүн утасдаж, сайхан асуулт асууна гэсэн баталгаа байхгүй. Эрсдэл ихтэй. Зарим үзэгч хараал, срөөл тавих, согтуу байх эрсдэл байнга байдаг. Энэ нь төсөөлж бичсэн зүйлээс чинь өөр үр дүнд хүргэх аюултай. *Vox-in-pops*-ийг гудамжнаас, эсвэл студид сууж байгаа үзэгчдээс асууж болно. Ер нь энэ тохиолдолд урьдчилан бэлтгээд хянаад явуулах нь зүйтэй байдаг. Тэгш саналыг өгч чадах уу гэдгийг сайн бодох хэрэгтэй. Та нар өөрсдийн боломжоор алиныг нь ч хийж болно.

Мөн хөтлөгчийн чадвар муу байх нь сүйрэл. Нэг үгийг бичихийн тулд үсэг үсгээр нь тасалж бичээд үг болохгүйтэй нэгэн адил телевизийн шоуг нэг л хүн эхнээс нь аваад дуустал нь удирдах ёстой. Эхлүүлээд л хаячихвал жинхэнэ сүйрэл болно. Тэгвэл үзэгчдээ алдаж, жинхэнэ “будаа” болно. Хүмүүс юу ч ойлгохоо болино шүү дээ. Хөтлөгчийн үүрэг бага хэмжээгээр заавал байх ёстой. Хөтлөгч нь хоёр нэр дэвшигчийг мөрөн дээрээ суулгаад, гараас нь хөтлөөд явах ёстой. Ерөөсөө хөтлөгчгүй мэтгэлцээн явуулна гэдэг хүүхдүүдийг хараа хяналтгүйгээр ойд аваачиж хаяхтай адил эзэнгүйрчихнэ шүү дээ.

20 минутын эфир байна гэж бодъё. Үзэгч энэ хугацаанд дэлгэцээсээ харц салгахгүй тас ширтээд сууж чаддаггүй шүү дээ. Сэтгэл зүйчид аль хэдийн энэ тухай судалсан. Үзэгчдийн харц нэг юмнаас нөгөө юм руу байнга шилжиж байдаггүйг тэд тогтоосон байдаг.




Тиймээс мэтгэлцээнийг ямар нэг хэмжээгээр хэсэг хэсэгт хуваахгүй бол үзэгчдийн сонирхол буурна. 10 минут өнгөрөхөд үзэгчдийн сонирхол багасна. Тиймээс 90 минутыг хэсэгчлэн хуваана. Хэсэг бүр драматург, сюжеттэй байх ёстой.


### ***Мэтгэлцээний зохион байгуулалт, бусад анхаарах зүйлс***

(Бичлэг үзүүлэв.) Танхимын зохион байгуулалт тайз, чимэглэл хийж байна. Их том танхим байгаа нь мэдрэгдэж байгаа биз дээ. Байраа хэсэгчлэн хуваасан. Нэр дэвшигчдийг 1.5 м x 1.5 метр хэмжээтэй тусгай өндөрлөсөн тавцан дээр зогсохоор төлөвлөсөн. Нэр дэвшигчдийн хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор өндөр тусгай тавцан тавьсан. Нэр дэвшигч нар тэр тавцангаас буух боломж олдохгүй. Энэ нь оператор ажиллахад дөхөмтэй байдаг. Оролцогч хаашаа я хамаагүй яваад эхэлбэл оператор өөрийгөө буудахаас өөр аргагүй болно. Тиймээс нэг газар зогсоох, эсвэл суулгах хэрэгтэй. Нэр дэвшигчдийн хоёр талаар суусан зочид тэднээс асуулт асуух эрхтэй, тэдэнд зориулсан камер ажиллана. Харин оролцогчдын өөдөөс харж суусан зочид асуулт асуух эрхгүй үзэгч байна.

(Дүрс үзүүлэв)



Мэтгэлцээний явцад эхлээд нэг нь ярина. Дараа нь нөгөө нь ярина. Тиймээс энэ дүрсийг дэлгэцэнд яаж өгөх вэ? гэдэг их чухал. Нэг нь ярьж байхад нөгөө оролцогчийн эхний оролцогчийг дэлгэцийн доод талд өгөх нь бүр сайн. Гэхдээ ганцхан энэ хувилбараар биш, өөр зөндөө олон хувилбар байж болно.



Бид нарт 9 камер байсан. Камер их байх тусам улам их сайн. Гэхдээ камерыг ил харагдуулахгүйгээр байрлуулах нь хүмүүсийн анхаарлыг



сарниулахгүй сайн талта Мэтгэлцээнд тохирсон өөрийн нэр байх ёстой. Мэтгэлцээнийг мэтгэлцээн гэж нэрлэвэл намайг эрэгтэй хүн гэж танилцуулсантай адил. Хүмүүс бие биендээ сонирхуулж ярихын тулд нэг их гоё, нэг их том биш юм аа гэхэд ямар нэгэн нэртэй байх ёстой. Бусад адил төрлийн нэвтрүүлэг, сувгаас ялгарахын тулд танай нэвтрүүлэг нэртэй байх ёстой. Нэргүй цацах тохиолдолд энэ нэвтрүүлэг нь бусад телевизээр яг нэгэн зэрэг цацдаг бол байж болно. Өөрөөр хэлбэл нэг байгууллага бэлтгээд бусад нь цацдаг бол байж болно.

Одоо Парламентийн сонгуулийн мэтгэлцээний жишээ харуулъя. (Бичлэг үзүүлэв.)

### *Парламентын сонгуулийн мэтгэлцээний жишээ*

Спорт, кино явуулдаггүй, “Шударга” нэртэй дан мэдээллийн суваг. Парламентийн мэтгэлцээнийг хоёр хөтлөгч хөтөлж байна. Хоёр нам тав таван гишүүдийн бүрэлдэхүүнтэй оролцож байна. Шинжээчид, асуулт асуух эрхтэй зочид бас энд харагдаж байна. Шинжээчдийг тусгайлан авсан байдаг. Эдийн засаг, экологи, нийгмийн салбарыг төлөөлж чадах хүмүүсийг сонгож авдаг. Шинжээчид асуултаа асууж байна. Хоёр гол өрсөлдөгч намаас оролцож байгаа. Шинжээчид болон зочдын асуусан асуулганд Нэр дэвшигчдийн хэн нь хариулахаа тавуулаа хэлэлцэж зөвлөлдөж байгаад шийддэгээрээ бидний өмнө үзсэн мэтгэлцээнүүдээс ялгаатай. Мөн нэг нь эхлээд нөгөө нь дуусгаж болно.

Мэтгэлцээн бол телевизийн шоу гэдгийг бүү март. Шоуны нэг зарчим хэдий чинээн их дүрс үзүүлж чадвал дүрслэл сайтай нэвтрүүлэг болдог. Нэвтрүүлгээ графикийн дүрслэлээр хэрхэн сайжруулах вэ гэдгийг бодолцох ёстой. Дүрслэлийн тухай хэлэхэд, эхлэл, төгсгөл, график, титр аль болох олон, баялаг дүрстэй байх ёстой. Одоо мэтгэлцээний өөр хэсэг эхэлж байна. Оролцогчид өөр хоорондоо асуулт тавьж байна. Нэг оролцогч нөгөөдөө асуулт тавьж байхад хөтлөгч оролцож байгааг анзаарч байна уу? Энэ мэтгэлцээний хувьд санхүүжилтийн хагасыг тухайн телсвиз өөрийн төсвөөс, үлдсэнийг доноруудаас авсан. Санхүүжилт сайтай, зардал ихтэй байсан. Сайн мэтгэлцээн болсон юм. Хөтлөгчийг эрэгтэй, эмэгтэй, эсвэл хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй гээд хүйсийн

хувьд яаж сонгож болдог. Гэвч хамгийн сонгодог хэлбэр нь эрэгтэй, эмэгтэй хоёр хөтлөгч байх явдал юм. Мэтгэлцээн нь харьцангуй богино нэвтрүүлэг боловч зардал ихтэй учраас юуны өмнө зардлаа багасгах, шардлагатай санхүүжилтээ олох нь хамгийн чухал. Украинд парламентийн сонгууль намын жагсаалтаар явагддаг бол танайд тойргоор явж байна. Иймээс манай мэтгэлцээний загварыг тэр чигээр нь авна гэдэг хэцүү байж магадгүй. Гэхдээ олон нам оролцсон хоёроос гурван нэр дэвшигчтэй мэтгэлцээн хийж болно. Дүрслэлийн хувьд хоёр хүн байснаас олон хүн орсон нь илүү сонирхолтой. Нам тус бүрээс тойрог, тойргоос дөрвөн хүн оролцуулаад мэтгэлцээн хийж болно.

Манайд намууд рейтингийнхээ жагсаалгаараа өрсөлддөг. Тухайлбал,

1-р нам 30%

2-р нам 20%

3-р нам 10%

4-р нам 3%

5-р нам 2%

6-р нам 1% гэх мэтчилэн рейтингтэй байдаг.

Жишээ нь, нэгдүгээрт бичиглсэн нам хамгийн сүүлд бичигдсэн намтай өрсөлдвөл үзэгчид үзэхгүй. Гэхдээ манай нөхцөлд бас сонирхож байна. Та 1-р нам, би 8-р намын учраас оролцохгүй байж магадгүй. Яагаад гэвэл, намын нэр хүндээс их шалтгаалдаг. 1-р намын хүн 8-р намтай мэтгэлцээнд орвол 1-р намын нэр хүнд шууд доошоо ордог. Эмэгтэй хүн хөгшин хүнтэй суувал таван жилийн дараа эрэгтэй нь залуу, эмэгтэй нь хөгшин харагддаг. Намын мэтгэлцээн үүнтэй адил. Тиймээс зохион байгуулахаас эхлээд эрсдэл, бэрхшээл бий болдог.

Хамгийн гол нь бүх юманд таардаг онол гэж байхгүй. Мэтгэлцээн ямар хэлбэрээр байж болох вэ гэдгийг би үзүүллээ. Зохион байгуулах арга техник олон байх тусам та нарт боломж олдоно. Ингээд хамгийн сүүлд яриад өнгөрсөн парламентийн мэтгэлцээн, Ерөнхийлөгчийн мэтгэлцээнээс юугаараа ялгаатай байна вэ?

**Оролцогчид:**

- Оролцогч, дүр дүрслэлийн хувьд баялаг.

- Хоёр хөтлөгчтэй
- Шинжээчид асуулт асууж байсан
- Гол нь парламентийн мэтгэлцээн хаана ч хийж болно. Ерөнхийлөгчийн мэтгэлцээн тосгон, суманд хийж болохгүй. Харин парламентийн мэтгэлцээн хийж болно.

Хоёр жилийн өмнө манайд Парламентийн сонгууль болсон. “Интерньюс”-ээс мэтгэлцээний төсөл хэрэгжүүлсэн. Орон нутгийн олон телевиз мэтгэлцээн явуулсан. Үүнээс өмнө зөвхөн Киевт мэтгэлцээн хийдэг байсан. Мэтгэлцээн хаана ч сонирхолтой байдаг. Киевт улсын хэмжээнд нэр хүндтэй хүн оролцож байсан. Харин орон нутагт тухайн газарт нэр хүндтэй бага албан тушаалын хүн оролцож болно. Нийт орон нутгийн 20 телевиз мэтгэлцээн хийсэн. 50/50 хувиар санхүүжилтийн болзол тавьсан.

Украины баруун хэсгийн жижиг хотод болсон мэтгэлцээнийг одоо үзүүлье. 30.000 орчим оршин суугчтай, хамгийн жижигт тооцогддог хот. Гурван нам оролцсон. Намын мужийн төлөөлөгч, хотын намын хорооны дарга оролцсон. Хонх дуугарч, цаг дуусч байгааг сануулж байна. Шууд мэтгэлцээн гэж титрээр бичсэн байна. 2006 онд 60 нам сонгуульд оролцож байсан. Бүгдийг мэтгэлцээнд оролцуулж, бас оролцуулахгүй байж болно. Намууд мэтгэлцээнд орохдоо мөнгө төлсөн. Төлбөртэй учраас оролцохоор мөнгөө төлсөн намуудыг тав тавар нь хувааж, цуврал мэтгэлцээн хийсэн. Эхний мэтгэлцээнд таван намын нэр дэвшигч өөрсдийнхөө танилцуулгыг хийж байна.

Мэтгэлцээн улс төрчдийн хандлага, сэтгэхүй, хэв маягт нөлөөлсөн юм. Одоо Украины улс төрчид шинэ маягаар ажиллах болсон. Ололт гарч ирж байгаа. Энэ их бүдүүн хүн байна. Би байсан бол энд оролцохгүй байсан. Энэ хүний дүрс дэлгэц дээр ямар муухай харагдаж байгааг ажиглаж байна уу? Хөтлөгч энэ төслийн санхүүжилтийн хагасыг донорууд өгсөн гэж хэллээ.

Мэтгэлцээний хоёрдугаар хэсэг эхэлж байна. Нэг нам нь нөгөөдөө асуулт тавьж байна. Асуулт, хариултын хугацаа хязгаартай, үүнийг хөтлөгчөөс хянаж байна. Гуравдугаар хэсэгт намууд мөрийн хөтөлбөрөө танилцуулж, ямар үүрэг, амлалт авч байгаагаа ярьж байна. Хамгийн гол нь мэтгэлцээнд оролцож байгаа хүмүүст тухайн орон нутагт юу хийх тухай асуулт тавьж, хариулт авч байсан.

Том асуудлыг хөндөөгүй. Яг нэг асуултыг оролцогч таван нам бүрт тавьсан. Нэг цагийн хоёр дахь мэтгэлцээн байсан. Энэ мэтгэлцээний нэр нь “Тоглоомын дүрэм”. Мэтгэлцээн тус бүр өөр өөр нэртэй байсан юм. Нэг нэр өгөхгүй байхыг бодолцсон. Яагаад гэвэл, Украинд олон жижиг хэл бий. Хоёр намын мэтгэлцээн болж байна. Хоёр хоёроор нь танилцуулсны дараа эрэгтэй оролцогч нь өрсөлдөгчөө эмэгтэй хүн хүндэтгээд эхлээд ярь гэсэн. Хоёр камертай мэтгэлцээн байсан.

Өөр дүүрэгт бас нэгэн мэтгэлцээн явж байна. Хоёр хөтлөгчтэй. Эхэнд нь мэтгэлцээнд оролцохоор зөвшөөрлөө өгсөн намуудыг нэрлэж байна. Урьдчилан бэлтгэсэн сюжетууд явж байна. Энэ телевизийн эзэн өөрөө нэр дэвшиж байгаа учраас бусдаас их ярьж байна. Энэ мэтгэлцээнд тэгш боломж, шударга байх зарчим алдагдсан гэж үзэж байна. Энэ мэтгэлцээнд 8-10 нам оролцсон. Шинжээч болон үзэгчидтэй нэр дэвшигчдийг нэг эгнээнд суулгасан. Хараат бус шинжээчдийг ажиллуулсан. Зарим телевиз мэтгэлцээний зардлаа намуудаас авсан юм. Энэ мэтгэлцээний хувьд намуудаас санхүүжилт аваагүй. 50 хувь орчмыг доноруудаас гаргасан. Хөтлөгч асуултаа асууж байна. Нэг индэртэй тайз учраас хөтлөгч, оролцогч нар ээлжлээд дэлгэцэнд гарч байна. Энэ нь техникийн бололцооноос болсон. Таван камер ажиллаж байна. Мэтгэлцээн Симфарополь хотод болсон. Бусад мэтгэлцээнтэй харьцуулах юм бол хамгийн хямд, бага санхүүжилттэй, зардал багатай мэтгэлцээн байсан. Мэтгэлцээний дундуур реклам цацаж байна.

Өөр нэг хотод болсон мэтгэлцээнийг одоо үзье. Энэ мэтгэлцээнд оролцогч намууд мөнгө төлсөн. Хөтлөгч энэхүү мэтгэлцээнийг “Интерньюс”-ийн төслийн хүрээнд явуулж байгаагаа хэлээд улс төрийн намуудыг танилцуулж байна. Энэ мэтгэлцээнд хөтлөгч, гурван нам, намуудыг дэмжигчид оролцсон.

Бүгдээрээ мэтгэлцээний загварыг эргэн саная.

- Эхлээд намууд өөрсдийгөө танилцуулна.
- Хоёрдугаарт намууд бие биедээ асуулт тавина
- Гуравдугаарт уригдаж ирсэн тусгай зочид, шинжээчид, студид байгаа үзэгчид асуулт тавина.

- Хөтлөгч мэтгэлцээнийг үйл явдлыг зарлахаас гадна үйл ажиллагааг удирдаж явуулна.
- Оролцогчдыг ярьж эхлэхэд цаг явж, дуусахад нь хонх дуугарна.

### **Мэтгэлцээнийг хэрхэн хөтлөх вэ?**

Юуны өмнө уригдсан намуудад зориулсан тусгай журам зохиогоод түүнийгээ танилцуулж, оролцохыг зөвшөөрсөн тохиолдолд намуудтай гэрээ хийж, гарын үсэг зуруулсан. Журамтай хамт мэтгэлцээний дарааллыг мөн явуулсан. Гэрээнд мэтгэлцээний явцад оролцогч гэрээгээ зөрчсөн тохиолдолд “эфирээс гаргана” гэсэн заалтыг оруулсан. Хоёрдугаарт , хөтлөгчдөд өндөр шаардлага тавьсан.

Телевизэд бусад нэвтрүүлэг, хөтөлбөрийн хөтлөгчийн ажлаас мэтгэлцээний хөтлөгчийнх өөр байдаг. Мэтгэлцээний хөтлөгч сайн сэтгүүлч байхаас гадна хоёр чухал шаардлага тавигддаг. Үүнд:

- Нэгдүгээрт, мэтгэлцээний хөтлөгч нам бус, намын харьяалалгүй, улс төрийн хувьд хараат бус байх ёстой. Парламентийн гишүүн байсан хүн мэтгэлцээнийг хөтлөгч байж болохгүй. Өөрөөр хэлбэл, улс төрд срөөсөө хугалдаагүй, улс төрийн ажил эрхлэж байгаагүй хүн байх ёстой.
- Хоёрдугаарт, энэ хүн зохих хэмжээгээр олонд танигдсан, нэр хүндтэй байх ёстой. Учир нь, мэтгэлцээний явцад улс төрчид хандан шаардлага тавьж чадах, түүний яриаг шууд таслан зогсоож чадах хүн байх ёстой. Маш сайн хөтлөгч ч хэдий ч яг ийм шаардлага, хатуу байр суурь баримталж чадахгүй эмээдэг тохиолдол гардаг.

Манайд болоогүй нурсан мэтгэлцээний нэг хөтлөгчөөр ажиллах ёстой байсан хэд хэдэн хөтлөгчийн нэг нь би байсан. Би үүгээрээ бахархаж байна. Яагаад би энэ цөөхөн хөтлөгчийн тоонд багтаж, шилэгдэж сонгогдсон бэ гэвэл, би улс төрчдөд бүгдэд нь дургүй. Үүнийг улс төрчид ч мэддэг. Энэ тухайгаа би

өөрийнхөө нэвтрүүлэгт ч хэлж ярьдаг. “Бүх улс төрч муу”. Энэ бол миний үзэл бодол. Өөрийнхөө нэвтрүүлэгт оролцож байгаа улс төрчийг би хувь хүнийх нь талаас илүү гаргаж, танилцуулдаг. Энэ нь аливаа сэтгүүлчийн хувьд хамгийн сайн шийдэл гэж боддог. Монголд ч, Украинд ч улс төрчид өөрийгөө хамгийн мундаг, шилдэг нь гэж боддог. Тиймээс тэдэнтэй харьцах сэтгүүлчийн хамгийн зөв байр суурь бол “ Би ард түмний нэг”. Тийм ч учраас ард түмэн юу асуухыг хүсч байна, би түүнийг л асууна. Тэр улс төрч ард түмэнд юу гэж хариулахаа надад хариулах ёстой гэж үздэг.

Мэтгэлцээний хөтлөгч зоригтой, хүчтэй байх ёстой. “Зогс, дараагийн хүн” гэж хэлэх зоригтой байх ёстой. Би “таныг биш гудамжинд байгаа иргэдийн дэмжиж байна” гэдгээ илэрхийлж чаддаг байх ёстой. Улбар шар хувьсгалын үеэр иргэнийхээ хувьд ч, сэтгүүлчийнхээ хувьд ч би Ющенког дэмжиж байсан. Гэхдээ Януковичийн үгийг түүнтэй ижил түвшинд хүргэх үүрэгтэй ажилласан. Энэ бол сэтгүүлчийн ганц зөв зам юм. Телевиз эмэгтэй төлөөлөл ихтэй залуу салбар. Мэтгэлцээний хөтлөгч нэг их залуу хүн байх ёсгүй гэж би боддог.

### **Мэтгэлцээний төсөв**

Черкасов хотын даргын сонгуулийн үеэр гурван долоон хоногт 32 намын 16 төлөөлөгч оролцсон. Янз бүрийн хотод мэтгэлцээнүүдийг зохион байгуулсан.

Тэднийг хамруулсан мэтгэлцээн зохион байгуулсан юм. Мэтгэлцээнээс өмнө бүх нам түүнд оролцоно гэсэн хариугаа бичгээр өгсөн байсан. Мэтгэлцээнд оролцсон улс төрийн нам бүр нэг минутанд 40 мөнгө төлсөн. Жижиг телевиз, жижиг хот учраас нэг цагийн эфирээс 400\$ олсон нь хангалттай сайн орлого гэж үзэхээр байв. Гурван долоо хоногт дөрвөөс таван мянган доллар олсон. Үүнээс гадна доноруудаас санхүүжилт авсан. Мөн “Интерньюс”-аас техникийн тусламж өгч, операторуудад нь сургалт явуулсан. Орон нутгийн жижиг телевизүүд энэ мэтгэлцээнүүдийг зохион байгуулсанаар “ажлын асар том туршлага хуримтлуулсан” гэж ярьж байсан. Мөн “Үүнээс өмнө хийж байсан ажлаас нь хамгийн том, хамгийн их хүч шаардсан ажил байсан” гэж дүгнэсэн юм. Тэдгээр мэтгэлцээн орон нутгийн улс төрийн хүчнүүдэд ч үр дүн үзүүлсэн

билээ. Телевизүүд хотынхоо нөхцөл байдалд сонгуулийн үеэр ажиллах арга барилаа өөрчилж чадсан юм. Бид Киевээс гол асуудлыг зангидаж байсан. Мэтгэлцээнүүд орон нутгийн улс төрчдөд өөрийгөө таниулах, жинхэнэ улс төрч шиг ажиллах боломж олгосон.

Бас өөр нэг телевиз нэг минутаа 10 доллараар үнэлж, өөрсдөөсөө 3500 доллар гаргасан. Тэд 7 удаагийн мэтгэлцээн хийсэн юм. Тэд “Мэтгэлцээн зохион байгуулсан мэдлэг, туршлагаа өөр нэвтрүүлэг бэлтгэхэд ашиглана” гэсэн юм.

Украины Парламентын сонгуулийн үеэр арилжааны гурван суваг мэтгэлцээн явуулсан. V суваг зардлынхаа хагасыг өөрсдөө, хагасыг нь доноруудаас олж, бусад хоёр нь улс төрийн сурталчилгааны хэлбэр болгож, намуудаас мөнгө авсан. Энэ хоёр сувгийн мэтгэлцээн амжилтгүй болсон билээ. Манай хуульд улс төрийн реклам ямар байх ёстойг товч, тодорхой заасан байдаг. Украинд телевизийн суваг бүр өөрсдийн үнэлгээг өөрийн дураар тогтоох нь заримд нь боломж олгож, зарим нь боломж олгохгүй байна гэж үздэг. Жишээ нь, би МАХН-ыг дэмждэг сувагт ажилладаг гэж бодъё. Тэгээд мэтгэлцээн хийхдээ МАХН-аас 50\$, АН-аас 100\$, бусад намаас 150\$ авч болохгүй. Бүгдэд нь тэгш хандах ёстой. Нөгөө талаас, миний сувгийг үзэж байгаа үзэгчид улс төрийн бодит байдлыг харж чадах болов уу? Манайд хамгийн анх телевизээр улс төрийн реклам цацахад нэлээд маргаан үүсч байсныг санаж байна. Сонгуулийн үеэр Украинд реклам, сурталчилгаа огт өөр зарчмаар явагдаг. Рекламын тухай хуулиар сонгуулиас бусад үеийн реклам сурталчилгааг зохицуулдаг. Харин сонгуулийн хуулиар улс төрийн сурталчилгааг зохицуулдаг. Улс төрийн реклам ердийн рекламнаас олон зүйлээрээ ялгаатай. Рекламын тухай хуулиар 60 минут тутамд 12 минут реклам явуулахыг зөвшөөрдөг. Телевизийн ихэнх суваг рекламны цагаа бөөнөөр нь реклам хийдэг байгууллагад зарчихдаг. Энэ нь зуучлагчдаар дамжуулж рекламаа цацдаг гэсэн үг юм. Тухайн сувгийн захирал, удирдлага хэдэн цагт ямар реклам явахыг мэддэггүй. Тодорхой хэмжээний мөнгийг рекламнаас жилийн дотор олдог. Өөрийн сувгийн рейтинг өсөх тусам рекламны үнээ өсгөдөг. Үзэгч тоолох төхөөрөмжийн тусламжтайгаар рейтингээ тооцож, гэрээт борлуулагч маягаар рекламны цагаа зардаг. Гэвч энэ систем сонгуулийн үеэр

ажилладаггүй. Харин телевизийн эзэн хэд хэдэн үйл ажиллагаа явуулдаг. Сурталчилгаанаас олсон мөнгөө аваад өмнөх жил олсон орлоготойгоо харьцуулж нэг минутын үнээ тогтоодог. Томоохон суваг нэг минутаа 100\$ гэж үнэлж болно. Гэхдээ бүх намд ижил үнэ барих зарчим л бүх сувагт үйлчилнэ. Арилжааны рекламг цацсанахаа дараа төлбөрөө авдаг бол, улс төрийн рекламг төлбөрийг урьдчилаад хэсэгчлээд авдаг. Мөнгө төлөх чадвартай хүнд эфирийн цаг өгөхгүй байх эрхгүй. Бүгд дугаарлаад цаг хүсвэл цаг хүрэлцэхгүй тохиолдолд хагаслаж өгдөг. Тэгш байдал гэдэг боломж олгохыг хэлнэ гэдгийг сайн ойлгох хэрэгтэй. Жишээ нь, Тариачны намд хотын төв телевизэд рекламны цаг авах шаардлага байхгүй. Авах эрхтэй боловч авах албагүй. Энэ рекламны төлбөрийг тухайн намын сонгуулийн төсвөөс гардаг. Улс сонгуулийн төсвийг баталдаг ч хэрэг дээрээ төсвөөс хамаагүй илүү мөнгө зарцуулагдсан байдаг. Хоёр долоо хоногийн өмнө Кисв хотын даргын сонгуулийн төсвийг 100.000\$ байх ёстой гэж хуульд заасан ч сонгуулийн даргын зардалыг нарийвчлан тооцооход 200.000\$ зарцуулсан байсан. отын даргад нэр дэвшиж буй таван нэр дэвшигчийн бүгдийнх нь төсөв нийлээд 100.000\$ гэж хуульд заасан атал нэг хүн 50 дахин илүү зардал гаргасан нь ил болсон. Нэг хүн ийм их мөнгө гаргаж чадахгүй нь ойлгомжтой. Энэ мөнгийг энд тэндээс хуримтлуулах ёстой болно.

Харин телевизүүд нэг минутыг 1100\$ гэж үнэлсэн байв. Намуудад мөнгө байсан ч бүгдийг нь нэг сувагт өгчихөж чадахгүй. Нэр дэвшигчдэд зориулсан нэг сюжетэд л 20-30 мянган доллар төлдөг. Гэхдээ үүнийг ил тодоор биш, нууцаар сонгуулийн сангаас хийнэ. Хэвлэл мэдээллийг хянах сонгуулийн хуулийн зохицуулалт манайд их сайн. Үүнд СЕХ хяналт тавьдаг. Ердийн нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаах амархан байдаггүй боловч сонгуулийн үед СЕХ-ы шийдвэрээр тодорхой хугацаанд шууд хаах боломжтой. Сүүлийн хоёр сонгуулийн үеэр Олон нийтийн зөвлөл байгуулж, СЕХ-д зөвлөмж өгч байсан.

Сонгуулийн явцад хэвлэл мэдээлэл сурталчилгааны их хүчтэй зэвсэг болдог. Тиймээс телевизүүдийг хянахгүй бол “сармагчинд гранат өгсөнтэй адил” гэсэн зүйр үгтэй адилтгаж болох юм. Сармагчин өөрийгөө болон бусдыг дэлбэлдэг гэсэн санаа юм. Энэ бол төрөөс тавьж буй хяналт биш. Сонгуулийн



үеэр телевизийг хянана гэдэг бол олон нийт хяналтаа тогтооно гэсэн үг юм. Энэ хяналт хоёр хэлбэртэй. Нэгдүгээрт, сайн хуулийн засаглал. Энэ тухай дахин дахин давтаж байгааг минь анзаарч байгаа байх. Сайн, тодорхой хуулийн засаглал маш чухал. Хоёрдугаарт, олон нийтийн байгууллагын хяналт. Олон нийтийн зөвлөл нь маш хүчирхэг, үр дүн бүхий зөвлөл байх ёстой. Улс төрчид үүнийг бий болгоогүй гэдгийг мартаж болохгүй. Тэд хаана ч ялгаагүй тэнэг, муухай хүмүүс байдаг. Үүнийг нийгмийн төлөө зүтгэж байгаа хүмүүс бий болгосон юм.

Яагаад “Интерньюс” СЕХ-д, хуулийн заалтад нөлөөлсөн бэ гэвэл дараах хүчин зүйлээс хамааралтай. Нэгд, Украинд 500 ХМХ-тэй ажилладаг. Хоёрт, 8000 гаруй сэтгүүлчийг сургаж, бэлтгэсэн. Гуравт, олон сайхан төсөл хэрэгжүүлсэн. Дөрөвт, олон улсын туршлагыг хэрэглэж сурсан. Тавд, санхүүгийн хувьд чадавхтай, мөнгөтэй байгууллага. Олон нийтийн Зөвлөлийг СЕХ, Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн Үндэсний Зөвлөл, сэтгүүлч, хуульчидтай хамтарч байгуулсан.

Улс төрийг хянах гэж байгаа учраас зөвлөлд улс төрчид оролцож болохгүй. Төрийн ажилтан өчигдрийн улс төрч байдаг.

Сайн мэтгэлцээнд их мөнгө хэрэгтэй тул сайн, бодитой төсөв хэрэгтэй.

Төсвийн бүтэц:

➤ **Урсгал зардал**

Мэтгэлцээний тухай урьдчилсан пи ар, сурталчилгаа их хийх хэрэгтэй. Хүмүүсийн сонирхлыг татах ёстой. Хүн бүр мэтгэлцээн болно, хэзээ, хэдэн цагт, хаана болох тухай мэдсэн байх ёстой. Энэ сурталчилгаанд бид 85.000\$ төсөвлөсөн. Шууд рекламанд 52.000\$, харин бусад зардал бага байсан. Хэвлэлийн бага хурал, орон нутагт танилцуулга хийх, бүх үйл ажиллагаанд мониторинг хийх зардал байсан.

- **Дизайны зардал.** 45.000\$ болсон. Үүнээс мэтгэлцээний ролик бэлтгэхэд 20.000\$, дагалдах материалын зардалд 17.000\$ төсөвлөсөн. Үүнд цүнх, футволк, нарны шүхэр гэх мэт.
- **Сюжет, богино хэмжээний кино.** 31.100\$ болсон. Мэтгэлцээн яаж явуулах, зохион байгуулах тухай кинонд 26.200\$, шинэ вэб сайт нээж ажиллуулахаар 5000\$ төлөвлөсөн байсан.
- **Захиргааны зардал** 34.000\$ төсөвтэй
- **Мэтгэлцээн явуулах үйл ажиллагааны зардал.** Энэ нь хоёр хэсгээс бүтнэ. Нэгдүгээр хэсэгт шууд үйл ажиллагааны зардалд 110.000\$, байрны түрээс, техникийн түрээс орсон. Төсөл дээр 40 хүн ажилласан. Нэг хүний дундаж цалин 1000\$. Гэхдээ янз бүрийн хугацаагаар ажиллах хүмүүс байсан.
  - Санал асуулгын зардал 2000\$. Ажиглах зөвлөлийн гишүүдэд 37.000\$ өгнө гэж тооцоолж байсан. **Нийтдээ 428.000\$** төсөвтэй байсан. Мэтгэлцээн болоогүй ч бид 250.000\$-ыг зарцуулсан. Судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. 1000-аас дээш санал асуулгыг манайд боломжийн дүн гэж үздэг.

### **Мэтгэлцээнд зочдоо хэрхэн урих вэ?**

Мэтгэлцээн тэнцвэртэй байдал, тэнцвэртэй нөхцөлд болох ёстой гэж дээр ярьсан. Мөн нөгөө талаасаа мэтгэлцээн бол шоу гэдгийг ердөө мартаж болохгүй. Мэтгэлцээнд зочдыг урихад энэ хоёр маш чухал.

Ер нь нэгд, өөрснөө юу хийх гэж байгаагаар сайн ойлгох хэрэгтэй. Бидний сургалтын үеэр үзсэн 5-6 жишээ бүгд өөр хоорондоо ялгаатай байсныг та нар анзаарсан биз дээ. Том, жижиг газар хийсэн нь чухал биш. Гол чухал зүйл нь энэ хөтөлбөрийг хэнд зориулж хийж байгаад оршино. Тиймээс эхлээд өөрсдөө бид үүнийг хэнд зориулж байгаа вэ гэдгийг сайн бодсон байх ёстой.

Телевизэд юу чухал вэ? Үзэгчдийн хамаг анхаарлыг дэлгэц рүү татаж, нүдийг нь бүлтгийлгэх ёстой. Үүнийг яаж хийх вэ? Үзэгчдэд чухамхүү танай суваг, танай нэвтрүүлэг хамгийн сонирхолтой, хамгийн чухал байх ёстой. Танай

нэвтрүүлэг үзэгчдэд үүнийг л үзье гэсэн сэдэл өгч байх ёстой. Үхэл, хагацал, секс, мөнгө, эрүүл мэнд, нэр алдартай хүн, сенсаац бүх хүнд л сонин байдаг. Харин мэтгэлцээнд бидний дээр нэрлэсэн бүх юм бий гэж бид хүмүүст итгүүлэх ёстой. Энэ бүгдийг нэг дор гаргахын тулд хэн оролцох нь тодорхой байх ёстой.

Хүн чаддаг юмаа хийж байж л амжилтанд хүрнэ. Нөгөө талаас хүнд хэрэгтэй юм хийж байж л амжилтанд хүрнэ. Телевизийн бүтээгдэхүүн бусад арилжааны бүтээгдэхүүнтэй адил. Телевизийн хөтөлбөр хүнд яаж хүрэх вэ гэвэл, бидний ярьсан энэ бүх зүйлийг багтаасан, сайн зохион байгуулсан байж л ашиг орлоготой бизнес болно. Бид орон нутгийн мэтгэлцээн үзсэн. Яг нэг дараалалтай мэтгэлцээн байсан. Гэсэн хэдий ч мэтгэлцээн нь өөр өөр болсныг та нар анзаарсан уу? Хэлний хувьд, оролцогчдын тоо, зочдын тоо явагдаж байгаа газраасаа хамаарч өөр өөр болсон. Тиймээс мэтгэлцээнийг дохион байгуулахдаа:

- Нэгд, чухам ямар хөтөлбөр бэ гэдгээ тодорхойлох ёстой
- Хоёрт, өөртөө болон бусдад зориулж тодорхойлон бичсэн зохиол(сценари), нэр, дараалал, дүрэм журам, хэдэн оролцогч байхыг бичих ёстой. Үүнийг улс төрийн намуудад, даргадаа, үзэгчдэд худалдах бүтээгдэхүүн гэж үзээд бүх зүйлийг тодорхой бичсэн байх ёстой
- Гуравт, мэтгэлцээний санхүүгийн төсөв сайн байх ёстой. Үүнд мэтгэлгэлцээнийг бусдад танилцуулах, рекламдах, сурталчлах зардал төсөвт суусан байх ёстой. Гайхамшигтай нэвтрүүлэг хийчихлээ, хийх гэж байна гэж бүх улс даяараа рекламдах хэрэгтэй
- Дөрөвт, урих хүмүүсээ нэрлээд яагаад урих болсоноо тайлбарлах хэрэгтэй. Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн хоёр нэр дэвшигчтэй байхад амархан, ойлгомжтой байна. Харин Парламентгийн сонгуульд нэг тойрогт 23 хүн өрсөлдөж байна гэж бодъё. Тэгвэл хорийг урьвал шоу биш болно. Хэн нэгнийг орхивол гомдоно. Үүнийг яаж шийдвэрлэх вэ?

Үүнийг шийдвэрлэж болох хэд хэдэн арга байж болно. Үүнд:

Нэгдүгээрт, төлбөр нэхэх. Тэгвэл сул нэр дэвшигч, мөнгө багатай нэр дэвшигч таны саналыг хүлээж авахгүй татгалзана.

Хоёрдугаарт, магадгүй таны хүссэн мөнгийг хориулаа өгье гэвэл яах вэ? Энэ тохиолдолд санал асуулгын дүнг ашиглах хэрэгтэй. Эхний гуравт байгаа ялах магадлалтай гэсэн хүмүүст санал тавих хэрэгтэй. Тиймээс социологийн дүнг ашиглах нь зүйтэй.

Гуравдугаарт, өөрийнхөө үзэмжээр хүнээ сонгох. Украинд телевизийн сувгууд янз бүр байдаг. Спортын, залуусын гэх мэтчилэн нийгмийн аль нэг хэсэгт зориулагдсан суваг ч бий. Тэгэхээр энэ гуравдугаар арга нь танай сувгийг хэн үзэх вэ гэдгийг мэдэх учраас та өөрөө хүнээ сонгох арга юм. Энэ арга нь хэл аманд өртдөг, хэцүү арга л даа.

Дөрөвдүгээрт, 20 хүнээс сугалаагаар шодож, таван хөтөлбөр хийе гэж бодё. Тэгвэл нэр дэвшигчдээ дөрөв дөрвөөр нь оруулж болно. Тэгвэл бүр амархан.

Тавдугаарт, оролцогчдод албан ёсны урилга хүргүүлэх ёстой. Энэ маш чухал бөгөөд албан ёсны толгойтой, тамга тэмдэгтэй, дугаарлагдсан, гарын үсэгтэй байх ёстой. Хуулбарыг нь архивлан авч үлдсэн, албан бичиг явууллаа гэсэн бүртгэлийг өөртөө байнга хийж байх ёстой. Энэ бол тун чухал шүү. Энэ албан бичигт хэзээ хариу өгөх ёстойг нарийвчлан зааж өгнө. Энэ нь бас нэгэн шоу болдог. Учир нь “Үр дүн гараагүй бол бас нэг үр дүн” гэсэн үг байдаг шүү дээ. Мэтгэлцээнд оролцохгүй гэсэн хариуг улс төрөөс гарах бодлого гэж үзэж болно. Оролцох эсэх тухайгаа бидэнд бичгээр явуулна гэж хүсэх хэрэгтэй.

Зургадугаарт, оролцогч нэг бүртэй гэрээ хийнэ. Мэтгэлцээнд ирэхийг зөвшөөрч, бичгээр хариу өгсөн хүнтэй энэ гэрээг хийнэ. Гэрээнд мэтгэлцээн явуулах цаг, хаана болох, ямар үнэтэй болох, хэдэн цагт эхлэх гэх мэтийг маш тодорхой бичиж, мэтгэлцээний дарааллыг нэг бүрчлэн цувруулж бичнэ. Гэрээнд мэтгэлцээний хэсгүүдээс өөр нэвтрүүлэгт оруулахыг хориглоно гэсэн заалт оруулна. Хөтлөгч болон бусад оролцогч тухайн хүнтэй хэрхэн харилцах тухай бичнэ. Үүнд: овгоор нэрээр дуудах, хэрхэн хандах зэргийн нарийвчлан бичнэ.

Гэрээнд мөн хөтлөгч хэн байх тухай бичиж, хөтлөгчид тавьж буй шаардлагыг тусгана. Бидний хийдэг гэрээгээр жишээ татъя.

1. Төвийг сахисан
2. Улс төрд оролцоогүй
3. Украин хэл төгс төгөлдөр эзэмшсэн байх чадвар /Украинд олон янзын аялгуу байдаг учраас аль нэг оролцогч хөтлөгчийн ярьдаг аялгаар ярьж эхэлбэл нэг нутгийн улс байна гэсэн мэдээлэл түгэхээс сэргийлдэг/  
Сайхан хоолойтой, тод хэллэгтэй байх ёстой
4. Туршлагатай /ижил төрлийн нэвтрүүлэг хөтлөж байсан туршлага/
5. Эрэгтэй хүн байх /амьдрал дээр эрэгтэй хүн эмэгтэй хүний биеэ барих сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар нь эрэгтэй хүн эмэгтэй хүнээс илүү гэж үздэг. Энэ бол олон улсын зарчим биш. Украинд дэлгэрсэн гэрээний нэг хувилбар.
6. Хөтлөгч нь оролцогч, үзэгчдийн хүндэтгэл хүлээсэн хүн байх ёстой.
7. Оролцогчдыг шууд таслан зогсоох чадвартай байх ёстой.
8. Хөтлөгч нь урьд өмнө телевизэд ажиллаж байгаагүй хүн байвал сайн

Мэтгэлцээн хийхэд өнөөдөр хоёр, маргааш гурав, нөгөөдөр дөрвийг урина гэх мэт тодорхойгүй байж болохгүй. Нэвтрүүлэгт оролцож магадгүй нэр дэвшигчид энэ нэвтрүүлэгт хоёр хоёр хүн оролцоно гэдгийг мэдэж байх ёстой. Нэг хүнд 30 минут ярих боломж олгоод дараагийн нэвтрүүлэгт гурван хүн орвол нэг хүнд 20 минут оногдоно. Тэгвэл тэгш шударга байх зарчим алдагдана. Бид нэг юмны тухай ярьж байхдаа бүгд л нэг ойлголттой байх ёстой. Хэзээ, хаана, хэдэн удаа хийсэн ч мэтгэлцээн бүгд ижил тэгш байх ёстой гэдгийг битгий мартаарай. Тухайн ганц нэвтрүүлэг бус цаашид үргэлжлэх мэтгэлцээнүүд ч ижил тэгш нөхцөлийг тэгш сайн хангах ёстой. Сонгосон загвараа гэсэн солих гэж чарахын хэрэггүй. Мэтгэлцээний загвар нь одоо оролцож байгаа, оролцох гэж байгаа хүмүүст ижил байх ёстой гэдгийг чухалчилж үздэг.

Мэтгэлцээний хөтлөгчийн ард ард түмэн байгаа, хөтлөгчийн нүд ард түмний нүд, хөтлөгчийн асуулт ард түмний хүссэн асуулт, хөтлөгч алдаа гаргавал түүний ар байгаа ард түмэнд муугаар нөлөөлнө. Хөтлөгч хүчтэй байвал ард түмэн хүчтэй байна.

Хөтлөгчийн үүргийн тухай ярья. Украины туршлагаас үзвэл, улс төрчид бие биеэ эсэргүүцэж үзэн ядсан найрсаг биш харилцаатай байдаг. Тиймээс хөтлөгчийн ажлаас бүх зүйл шалтгаалдаг. Мэтгэлцээн болох болохгүй нь хөтлөгчөөс шалтгаалж байсан тохиолдол ч бий. “Хөтлөгч хэн бэ?” гэдэг нь нэр дэвшигч мэтгэлцээнд ирэх ирэхгүйгээ шийдэхэд хамгийн ихээр нөлөөлдөг зүйл юм. Олон улс төрч мэтгэлцээний хөтлөгчдөд итгэхгүй байна гэдэг. Яагаад гэвэл, тэд хөтлөгчийн тэнцвэртэй байдалд эргэлзэж байсан. Гэрээнд яагаад хөтлөгчид тавих шаардлагыг жагсаадаг вэ? Улс төрчид, ард түмэн бидэнд итгэх итгэлийг олж авахын тулд эхнээс нь хэн, хаана, яаж ажиллах вэ гээд юуг ч орхилгүйгээр толгой дараалан мэдэж байвал энэ нэвтрүүлэг эхнээсээ аваад хүн бүхний мэдэх хэмжээнд очиж чадна. Хөтлөгч нь туршлагатай нэр хүндтэй шийдвэр гаргахдаа зоригтой хүн байх ёстой. Олон улсын туршлагаас харахад, мэтгэлцээний өмнө “Энэ хүн хөтөлнө” гэж урьдчилан зарладаг.

Манай гэрээнд “хөтлөгч нь телевизэд урьд өмнө ажиллаж байгаагүй хүн байвал бүр сайн” гэж зааж өгсөн. Хөтлөгч нь сонин болон радиогийн сэтгүүлч байж болно. Сайн бэлтгэгдсэн, өөр мэргэжлийн хүн байж болно. Хэрэв ийм хүнээр хөтлүүлэхээр шийдсэн бол урьдчилан бэлтгэх ёстой бөгөөд үүнийг тракт гэж нэрлэдэг. Тракт гэдэг нь зам мөр гэсэн утгатай үг. Тэр хөтлөгчид орчныг мэдрүүлэх, камертай харьцах, асуултаа хэрхэн тавих, оролцогчдыг хэрхэн залах, мэтгэлцээнийг удирдах, хэрэгтэй үед нь таслан зогсоох зэрэгт сургаж, заавал урьдчилан бэлтгэх ёстой. Урлагийн ямар нэгэн тоглолтын өмнө прогон хийнэ гэдэг шиг бид ч гэсэн мэргэжлийн бус хүмүүстэй заавал тракт хийх хэрэгтэй. Ердийн спортын нэвтрүүлэгт спорт сайн мэддэг хөтлөгч, улс төрийн нэвтрүүлэгт улс төр мэддэг хөтлөгч байх ёстой. Харин мэтгэлцээнд хөтлөгчийн үүрэг маш бага. Гадаа тэнэж яваа нохой, хашаан дотор гинжинд уяатай байгаа нохой байя гэж бодъё. Гудамжны нохой чөлөөтэй, хашаа ч явж чадна. Харин уяатай нохой уяныхаа дотор эргэлдэж, уяндаа тулаад үүрэг нь дуусна.

Ердийн нэг нэвтрүүлэгт хөтлөгчийн үүрэг хамгийн их. Зарим тохиолдолд хөтлөгч ганцаараа бүх юмаа үүрээд гарах ч бий. Тэр өөрийнхөө үзэмжээр нэвтрүүлгээ удирддаг. Энэ хүн сайн, тэр хүн муу гэж ярьдаг хөтлөгч ч бий. Энэ сэдвийг орхиё гээд орхиод ч явж болдог. Харин мэтгэлцээний хөтлөгч

энэ бүхнийг хийж болохгүй. Танд асуулт тавина, танд тавихгүй хэлэх эрхгүй. Дууныхаа өнгө, нүүрний хувиралаар оролцогчдыг дэмжсэн, эс дэмжсэн өнгө аяс гаргахгүй. Хоёр оролцогчтой, хоёр өөр өнгө аясаар харьцаж байгаа нэвтрүүлэг ч үзсэн. Мэтгэлцээнд үүнийг зөвшөөрдөггүй. Хөтлөгч ямар үйлдлийг яаж хийхийг нарийвчлан зааж өгдөг.

### **Хөтлөгчийн үүрэг**

Нэгдүгээрт, хөтлөгч мэтгэлцээнийг нээх ёстой. Үзэгчдэд мэтгэлцээний тухай тайлбарлах ёстой.

Хоёрдугаарт, мэтгэлцээний оролцогчдыг танилцуулах ёстой. Ингэхдээ оролцогчдыг адил тэгш байдлаар танилцуулах ёстой гэдгээ мартах ёсгүй. Нэгийг нь нэр хүндтэй нэр дэвшигч гэхихээд, нөгөөг нь нэр дэвшигч гэдэг ч юм уу, эсвэл Монголын тухай сайн зүйл хийх хүн гэж болохгүй. Нэг ижил түвшний мэдээлэл өгөх ёстой.

Гуравдугаарт, оролцогчдын цагийг хянах ёстой. Мэтгэлцээн адил тэнцүү цагийн хэмжээтэй байх ёстой. Цагийг өлгөж, эсвэл дэлгэцэнд титрээр өгч болно. Ямар ч байсан мэтгэлцээн бүр цагтай байна.

Дөрөвдүгээрт, мэтгэлцээн эхлэхийн өмнө сэдвийг танилцуулах үүрэгтэй.

Тавдугаарт, оролцогчдод ижил төрлийн асуулт тавина.

Зургадугаарт, нэр дэвшигч сэдвээс гадагш хальж эхэлбэл таслан зогсооно

Долдугаарт, мэтгэлцээнийг дуусгана. Энэ хамгийн сүүлчийн үүрэг юм.

Улс төрчид хаана ч байсан улс төрийн тухай ярих нь тэдэнд илүү хялбар байдаг. Харин ердийн хүмүүсийн асуултанд хариулах нь тэдэнд хэцүү. Жишээ нь: Байгаль орчны талаар асуулт тавихад улс төрч аль болох бултах, зугтах арга зам хайж, “Би байгальд хайртай. Та нар мэдэж байгаа” гэх мэтийг хэлээд хуулийн талаар ерөнхий тайлбар хийнэ. “Монгол ардын хувьсгалт нам юу ч хийж чадахгүй. Харин бид л үүнийг хийнэ. Биднийг л сонго” гэвэл хөтлөгч үүнийг шууд зогсоогоод: “Би танаас байгаль орчны тухай асуусан болохоос

МАХН ямар вэ гэж асуугаагүй. Гол ус ширгэж байна. Үүнийг зогсоохын тулд та юу хийх вэ гэж асуусан” гэх нь хөтлөгчийн үүрэг.

Телевизийн ердийн нэвтрүүлэг хөтлөхөөс мэтгэлцээн хөтлөх нь илүү хүнд. Хөтлөгч нь тухайн хөндөгдөж байгаа асуудал сэдвийн тухай мэтгэлцээнд оролцож байгаа нэр дэвшигчдээс илүү мэддэг байх хэрэгтэй. Жинхэнэ сэтгүүлч хүн улс төр, эдийн засаг, нийгмийн асуудал, гадаад бодлого зэргийг сайн мэдэж байх ёстой. Тухайлбал, оролцогч байгаль орчны сэдвээр худлаа яриад, эсвэл булгаж булзааруулаад байвал “Уучлаарай, энэ гол өчигдөр биш гурван жилийн өмнө ширгэсэн шүү дээ” гэнэ. “Хууль гаргасан” гэвэл “Үгүй, батлагдаагүй” гэж хэлэх ёстой.

Хөтлөгчийн ар талд ард түмэн бий гэдгийг сана. Хөтлөгчийг оролцогч хуурах гэж оролдвол энэ нь ард түмнийг хуурах гэсэн оролдлого гэж үзнэ. Хөтлөгч кохиолын дагуу нэвтрүүлгээ чиглүүлж хөтлөх ёстой. Тиймээс энэ хүн юу ярих вэ гэдгийг урьдчилан таамаглах чадвартай байх ёстой юм.

Шинэ сэтгүүлч асуултаа онолгүйгээр “Үүний талаар та юу бодож байгаагаа хэлээ” гэхээр нөгөө хүн баахан худлаа ярьдаг. Бүтэн хальс дүүрэн худлаа ярьдаг. Ажил дээрээ очоод хальсаа хэд дахин эргүүлээд ч хэрэгтэй зүйлээ огт олж чаддаггүй. Тиймээс та гурван өгүүлбэрээр хариулж өгөөч гэж хэлэх хэрэгтэй. Яагаад гэвэл, би тэр хүнийг юу гэж хариулахыг мэдэж байгаа учраас. Сэтгүүлч хүн нэг сэдвийг ойлгохын тулд маш удаан ажиллах ёстой. Өдөр тутмын үйл явдлаар мэдээ бичиж байвал та сэтгүүлч биш. Зөвхөн миний цамцаар мэдээ хийе гэвэл зарим нь улаан, зарим нь ягаан, зарим нь халтар гэх юм бол тэр бүхнийг оруулах ёстой болдог. Мэргэжлийн сэтгүүлч эх сурвалжтай харьцахыг яагаад би энд хөндсөн бэ? Яагаад гэвэл, миний амьдралд нэг асуултыг найман удаа тавих тохиолдол гарч байсан. Уригдаж ирсэн оролцогч таны асуултанд хариулахгүй бол таныг болон таны ар талд байгаа ард түмнийг хуурч байна гэсэн үг. Хариулахаас булгаад байсан учраас нэг асуултаа найман удаа тавьсан. Гэвч энэ аргыг мэтгэлцээнд хэрэглэж болохгүй. Мэтгэлцээний хөтлөгчийн амар хялбар тал нь өөрийнхөө уянд л гүйнэ. Муу тал нь уянаасаа алдуурч магадгүй.



Нэр дэвшигч хадуурч эхэлбэл таслан зогсоох хэцүү бол шууд заставка буюу завсарлага өгөх арга байж болно.

Найруулагч дүрсээ аваад өөр дүрс өгч болно. Эсвэл хөтлөгчийн дургүйцлийг дэлгэцэнд өгч болно. Энэ үед хөтлөгч тухайн оролцогч мэтгэлцээний журмыг зөрчиж байгааг үзэгчдэд тод хэлэх ёстой.

### ***Мэтгэлцээний үед найруулагч оператор хэрхэн ажиллах вэ?***

Дүрсний хувьд хөтлөгч дандаа обций плантай байх ёстойг найруулагч анхаарах хэрэгтэй. Крупный, средний зэргээр авч болохгүй. Яагаад гэвэл, үзэгчдийн гол анхаарлаа хандуулах хүн хөтлөгч бус оролцогч байх ёстой.

Мэтгэлцээний үед гарч болох бэрхшээл: Оролцогч худлаа ярих, сэдвээс халих, цаг барихгүй байх зэргийг үзнэ. Оролцогч яаж ч зөрчлөө гэсэн цагаа зогсоохгүй, мэтгэлцээнийг зогсоож болохгүй. Тиймээс л бидэнд мэргэжлийн, чанартай мэтгэлцээн хийхэд суралцах шаардлага гарч ирдэг.

(Хөтлөгчийн чадварын тухай бичлэг үзүүлэв)

***Жишээ 1:*** Хөтлөгч средний планаар дүрэм танилцуулж байна. Цаашид обций план

***Жишээ 2:*** Эрэгтэй эмэгтэй хоёр хөтлөгчтэй оролцогчдыг эрэгтэй хөтлөгч чиглүүлж байна. Кранаар зураг авалт хийгджээ.

Тарас Шевченко “Тэмц, тэгвэл ялна” гэж хэлсэн. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш Украинд айчлахдаа энэ үгийг давтсан. Хамгийн ухаантай сод хүүхэд ч шууд босоод гүйчихдэггүй. Нэг алхана. Унана. Урагш алхах тусам алхам бүр чинь их байж алхах тоолондоо унахгүй байхыг ерөөс.

Та нарт сургалтын үед олон дахин давтаж байсан зүйлээ дахин хэлье. Бидний гол үүрэг бол бид хүний төлөө ажиллаж байгаа юм шүү. Сэтгүүл зүй стандартыг мөрд! Тэгвэл бүх юм чинь сайхан болно.

## *Украины хэвлэл мэдээлэл*

Украинд өнөөдөр 20 мянга гаруй сонин, 2000 гаруй телевизийн суваг үйл ажиллагаа явуулдаг. Гэхдээ хамгийн идэвхтэй нь 1000 гаруй байгаа. Украин нь 46 сая хүн амтай. Зөвхөн Киев хотод 5 сая хүн амьдардаг.

Өнгөрсөн жил, хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 1000 гаруй телевизийн суваг нийтдээ 1.5 сая долларыг рекламаас олсон. Телевизийн хамгийн том суваг нэг сая доллараар худалдагдсан. Рейтингээрээ 8 дугаарт ордог суваг 300 сая доллараар борлогдсон. 1996 оноос хойш телевизийн ганц улсын суваг ажиллаж байгаа. Энэ нь рейтингээрээ 10 дугаарт жагсдаг.

Зүгээр сайн залуус учраас гэж хэн ч реклам өгөхгүй. Украинд реклам олгогчид тухайн суваг, тухайн нэвтрүүлгийг хэзээ, хэдэн хүн үзсэнийг сайн мэдэж байж, рекламаа өгдөг юм. Манайд үзэгчдийг тоолох аппарат буюу Peoplemeter-тоологч ашигладаг. Телевизийн том сувгууд тэдний ямар нэвтрүүлгийг хэдэн цагт хичнээн хүн үзэж байгааг бодитой тогтоохын тулд тоологчийг өөрсдөө худалдан аваад, 10.000 айлын телевизорт суулгасан. Тухайн өрхөд зохих хөлсийг төлдөг. Гэр бүлийн гишүүн бүр өөр өөрийн удирдлагатай. Тоологчийг ямар нэг сонголт, шалгуургүйгээр жирийн айлуудад тарааж өгсөн. Өөрөөр хэлбэл, тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамааралгүй гэсэн үг юм. Тоологч тоон мэдээлэл цацаж байдаг учраас телевизийн захирлууд өглөө бүр тэдгээр тоон үзүүлэлтийг үзэхээс ажлаа эхэлдэг. Тоологч срөнхий мэдээлэл цацахаас гадна үзэгчдийн бүрэлдэхүүн, тухайлбал, үзэгчдийн хэдэн хувь нь эмэгтэйчүүд, өсвөр насныхан болох, тэд хэдэн цагийн хооронд аль телевизийн аль нэвтрүүлгийг үзсэн бэ гэсэн олон нарийн үзүүлэлтийг харуулдаг. Тиймээс энэ тоологчоор хэн, хэзээ, юу үзсэнийг тасралтгүй тодорхойлж болдог. Ийм үзүүлэлтгүйгээр ямар ч суваг хэзээ ч реклам авч чадахгүй.

## **Телевиз бол хүний итгэлээс шалтгаалах бизнес.**

Украинд энэ төхөөрөмж үр дүнгээ өгсөн. Манайд “Сайн мэдээлэл өгсөн нь сайн ашиг олно” гэсэн зарчим үйлчилдэгтэй холбоотой. Рейтинг тухайн нэвтрүүлгийн санхүүгийн байдлыг дээшлүүлнэ. Таван минутын рекламаас 10.000 ам. доллар олж болно.

Украинд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай олон хууль бий. Манайд телевизийн үйл ажиллагааг зохицуулах тусгай, хараат бус байгууллага байгууллага байдаг.

Украинд төрөөс хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл давамгайлж байгаа. Төрийн хэвлэл нэлээд бөглүү, алслагдмал газар л нэр хүндтэй байдаг. Мэдээж нийслэлийнхэн төрөөс хараат бус, хэвлэл мэдээллийн өөр хэрэгслийг хүлээн зөвшөөрдөг.

Манайд Интернет чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийт хүн амын 20 хувь нь интернетээс мэдээлэл авдаг гэсэн судалгаа бий. Интернет рекламнаас жилд 100 сая ам.долларын орлого олдог. Интернет ашиглах, цахим бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь илүү зардал багатай.

Украинд сэтгүүлч бэлтгэдэг 40 сургууль бий. Харамсалтай нь, тэдгээрээс хоёр нь муу, 38 бүр муу ажиллаж байна. Энэ бол хамгийн том асуудал. Сэтгүүлч бэлтгэдэг байгууллагууд хийх ёстой зүйлээ хийхгүй байна.

## ТЭМДЭГЛЭЛ